# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 3 дугаар сарын 24-ны өдөр | Дугаар 97 | Улаанбаатар хот |

“Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам” батлах тухай

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 23.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журамд заасан үйл ажиллагаатай холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-д даалгасугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н. Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН